




F I N A N C E

“МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО”

3. Мэдээллийн аюулгүй байдлын бодлого

3.1 Мэдээллийн аюулгүй байдлын бодлогын хүрээнд бид дараах зорилго, зорилтуудыг дэвшүүлэн ажиллана.

3.1.1 Энэхүү бодлого нь байгууллагын стратеги зорилт, эрсдэлийн удирдлагын хүрээ болон хууль эрх зүйн шаардлагыг дэмжсэн, байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны суурь чиглэл, зарчмыг тогтооно.

3.1.2 Компанийн хувьцаа эзэмшигч, ажилтан, зээлдэгчид болон харилцагч байгууллагуудын мэдээллийг аюулгүй байлгах, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах болон олон улсын финтекийн зах зээлд тэргүүлэгч бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэгч болохын тулд мэдээллийн аюулгүй байдлын стандарт тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлэн сайжруулалтыг тогтмол хийх;

3.1.3 Компани нь харилцагч болон технологийн түншүүдтэй хамтран ажиллахдаа мэдээллийн хүртээмжтэй байдал, бүрэн бүтэн байдал болон нууцлалыг нэн чухалд тооцно.

3.1.4 Мэдээллийн аюулгүй байдлын зорилтуудыг жил бүр тодорхойлж, баталж, хэрэгжилтийг хэмжих, хянах бөгөөд эдгээр зорилтыг байгууллагын стратеги чиглэл болон энэхүү бодлогын суурь зарчимтай уялдуулан тогтооно.

Гүйцэтгэх захирлын 2025 оны 11 дугаар
сарын 24-ний өдрийн 25/027 тоот
тушаалын хавсралт 01



- 3.1.5 Мэдээллийн аюулгүй байдлын бодлого болон түүнээс урган гарах бүх зорилго, хяналт нь байгууллагын стратеги төлөвлөгөө, бизнесийн хөгжлийн чиглэлийн хэрэгжилтийг дэмжсэн байдлаар уялдаатай байна.
- 3.1.6 Байгууллага нь мэдээллийн нууцлал (Confidentiality), бүрэн бүтэн байдал (Integrity), хүртээмжтэй байдал (Availability)-ийг хангах нь МАБМТ-ын үндсэн суурь зарчим болохыг хүлээн зөвшөөрч, эдгээрийн хангалтыг бүх түвшний ажилтанд мөрдүүлэхийг зорьно.
- 3.1.7 Эрсдэлийг хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл бууруулахын тулд мэдээллийн аюулгүй байдлын багц журам, стандарт, процесс, үйл ажиллагааны заавар болон хяналтуудыг хэрэгжүүлэх;
- 3.1.8 Хандах эрхийн зохих хяналт, хязгаарлалтыг хэрэгжүүлэн, халдлагаас урьдчилан сэргийлэх;
- 3.1.9 Байгууллага, болон харилцагч, гэрээт гуравдагч талуудын мэдээллийн нууцлалыг ханган ажиллах;
- 3.1.10 Мэдээллийн аюулгүй байдлын тасралтгүй байдлыг хангах, ажилчдын мэдлэг ур чадварыг хөгжүүлэх;
- 3.1.11 Мэдээллийн аюулгүй байдлын зөрчлийг мэдэгдэх, тайлагнах, хүлээн авах орчныг бүрдүүлж учир шалтгааныг шинжилж, залруулах, ирээдүйд дахин тохиолдохоос сэргийлэх арга хэмжээ авдаг байна.
- 3.1.12 Мэдээллийн нууцлалыг хамгаалах: Мэдээллийн хөрөнгө нь компанийн өмч бөгөөд түүний бүрэн бүтэн байдал болон нууцлалыг чанд хамгаална.
- 3.1.13 Хууль тогтоомж зохицуулагч байгууллагын шаардлагыг хангах: МАБ хангах зорилгоор Монгол улсын хууль зохицуулагч байгууллагын МАБ тай холбоотой дүрэм журам (Кибер аюулгүй байдлын тухай хууль, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль, Тоон гарын үсгийн тухай хууль болон дагалдах журам) стандартын шаардлагад нийцсэн байна.
- 3.1.14 Бизнесийн тасралтгүй байдлыг хангах: Компанийн үнэт цаас эзэмшигч, үйлчилгээ үзүүлэгч харилцагч байгууллагууд болон харилцагчийн МАБ хангах нөхцөлийг бүрдүүлж бизнесийн үйл ажиллагааны тогтвортой тасралтгүй байдлыг хангахад чиглэнэ.
- 3.1.15 Бизнесийн харилцаа: МАБ менежментийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэгч байгууллага үүрэн холбоо банк төсөл хэрэгжүүлэгч гэх мэт төрийн болон хувийн байгууллагуудтай гэрээ байгуулж хамтарч ажиллахдаа МАБМТ стандартын шаардлагыг хангахуйц байхыг зоринo.
- 3.1.16 Сонирхогч талуудтай харилцахдаа энэхүү бодлогын холбогдох хэсгийг ил тод байлгаж, шаардлагатай нөхцөлд тэдэнд хүргэх бөгөөд хуулийн шаардлагын хүрээнд хуваалцана.
- 3.1.17 МАБ эрсдэлийн удирдлага: МАБ эрсдэлийн төрөл үнэлгээний шалгуур үзүүлэлт хүлээн зөвшөөрөх хязгаар тэдгээрийн эздийг тодорхойлохдоо Эрсдэлийн удирдлагын бодлогод заасны дагуу удирдаж тодорхойлно.
- 3.1.18 Бид байгууллагын аливаа мэдээлэл нь Бидний үнэ цэнэтэй өмч хөрөнгө гэдгийг хүлээн зөвшөөрч тэдгээрийг зөвшөөрөлгүй задруулах өөрчлөх эсвэл устгахаас бүрэн хамгаалж хэрэглэхэд бэлэн байлгаж мэдээллийн аюулгүй байдалд учирч болох эрсдэлийг хамгийн бага байлгах үүднээс МАБ бодлого дүрэм журмыг боловсруулан хэрэгжүүлж тэдгээрийг өдөр тутамдаа мөрдлөг болгох;

Гүйцэтгэх захирлын 2025 оны 11 дугаар
сарын 24-ний өдрийн 25/027 тоот
тушаалын хавсралт 01



- 4.1 Дээд удирдлага нь бодлогын хэрэгжилтийг хангахын тулд шаардлагатай чиглэл, дэмжлэгийг бүх түвшний удирдлага болон ажилтнуудад үзүүлнэ.
- 4.2 Удирдлагын үүрэг хариуцлага: "Мэйн Стрит Финанс ББСБ" ХХК-ийн Гүйцэтгэх удирдлагын зүгээс Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог бий болгоход манлайлан тэргүүлж, үүрэг хариуцлагаа ухамсарлан ажиллаж, манлайллаа дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд:
- 4.2.1 Мэдээллийн аюулгүй байдлын зорилгыг тодорхойлох, бодлого боловсруулах, тэдгээрийг байгууллагын стратеги чиглэлтэй уялдуулах
- 4.2.2 Компанийн үйл ажиллагаанд МАБМТ-ын шаардлагуудыг уялдуулах
- 4.2.3 МАБМТ-нд шаардлагатай нөөцүүдийг хүртээмжтэй байлгах
- 4.2.4 Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын ач холбогдлыг ойлгуулах, үр дүнтэй нэвтрүүлэхэд оролцогч талуудыг чиглүүлэх, дэмжлэг үзүүлэх
- 4.2.5 Тасралтгүй сайжруулалтыг дэмжих
- 4.2.6 Дээд удирдлага нь МАБ-ын соёлыг төлөвшүүлэх, мэдлэг олгох, шаардлагатай төсөв, нөөцөөр хангах, эерэг зан үйл төлөвшүүлэх, бодлогын хэрэгжилтийг хангахад хариуцлагатай хандах
- 4.2.7 МАБМТ-ын үр дүнтэй хэрэгжилтийг хангахын тулд хүний нөөц, техник технологи, санхүүгийн эх үүсвэр болон шаардлагатай бусад дэмжлэгийг удирдлага тогтмол хангана.